ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2025/035/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827 Цахим хаяг:khulankhatanb@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 289

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ш.ЖАВХЛАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,045,263.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 1,037,813.8 мянган төгрөгийг зарцуулж, 7,450.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 321,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,108.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн 15.0 хувь буюу 156,955.6 мянган төгрөг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, 6.8 хувь буюу 70,799.0 мянган төгрөг нь ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал эзэлж байна. Тайланд онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 9 хуралдааныг зохион байгуулж, хичээл үйлдвэрлэлийн зардалд 51,844.4 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсний 67.2 хувь буюу 34,856.8 мянган төгрөг нь хуралдааны хоол, цайны зардалд зарцуулагдсан байна. Иймд дээрх зардлуудыг Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах шаардлагатай байна.

232520289

Хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулж, батлагдсан маягт зааврын дагуу тооллогын бүртгэлийг хөтөлж, тооллогын тайлан, илтгэх хуудас бичиж үлдэгдлийг баталгаажуулан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэн, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа олгох мөнгөн урамшууллыг Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" -ын шалгуур хангаагүй ажилтанд олгосон, төрийн захиргааны албан хаагчид олгох мөнгөн урамшууллаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хувиар албан татвар ногдуулж, суутган шилжүүлээгүй 11,934.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоолоо.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 94.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,055,606.00** | **31,751,730.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 110,700.00 | 110,700.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 110,700.00 | 110,700.00 |
| **3121** | **Төгрөг** | 110,700.00 | 110,700.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 110,700.00 | 110,700.00 |
| **33** | **АВЛАГА** | 690,876.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 582,776.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 108,100.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 108,100.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 30,254,030.00 | 31,641,030.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 30,254,030.00 | 31,641,030.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 614,550.00 | 614,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,977,480.00 | 28,364,480.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,662,000.00 | 2,662,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **82,163,938.17** | **83,146,750.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 82,163,938.17 | 83,146,750.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | 82,163,938.17 | 83,146,750.99 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 176,790,308.00 | 176,790,308.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (131,041,666.49) | (139,899,728.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 51,397,908.40 | 55,385,808.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (28,113,936.28) | (35,507,091.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,441,860.50 | 41,351,860.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (17,310,535.96) | (18,974,405.96) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 320,000.00 | 320,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (320,000.00) | (320,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **113,219,544.17** | **114,898,480.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **113,219,544.17** | **114,898,480.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 113,219,544.17 | 114,898,480.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 102,550,728.00 | 102,550,728.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 102,550,728.00 | 102,550,728.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,101,260.17 | 8,780,196.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,101,260.17 | 7,101,260.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,678,936.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,567,556.00 | 3,567,556.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **113,219,544.17** | **114,898,480.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,638,204,508.00** | **1,372,651,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **33,587,908.00** | **3,388,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **33,587,908.00** | **3,388,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,790,308.00 | 3,388,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 31,790,308.00 | 3,388,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,797,600.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,604,616,600.00** | **1,369,263,800.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **848,776,000.00** | **324,000,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,776,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 840,000,000.00 | 321,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **755,840,600.00** | **1,045,263,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 755,840,600.00 | 1,045,263,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,597,063,797.11** | **1,370,972,863.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,597,063,797.11** | **1,370,972,863.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,477,381,567.25** | **1,177,143,868.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **340,812,727.26** | **458,999,694.10** |
| 210101 | Үндсэн цалин | 196,107,763.49 | 252,743,479.01 |
| 210102 | Нэмэгдэл | 79,909,182.49 | 139,582,357.73 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,450,036.20 | 35,714,617.27 |
| 210104 | Урамшуулал | 23,259,390.77 | 30,959,240.09 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,086,354.31 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,257,081.47** | **58,424,505.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,923,485.23 | 39,955,543.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,402,763.03 | 4,632,090.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,498,450.58 | 2,306,145.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,049,366.08 | 2,306,145.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,383,016.55 | 9,224,580.97 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,346,779.50** | **29,507,230.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 673,600.00 | 815,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,913,999.50 | 25,510,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,714,180.00 | 3,181,830.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 45,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,204,900.00 | 23,794,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,801,500.00 | 1,324,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 3,212,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,403,400.00 | 19,257,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **22,977,000.00** | **30,676,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,977,000.00 | 30,676,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **115,892,064.00** | **182,463,186.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 112,633,367.00 | 179,343,868.34 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000,000.00 | 2,943,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 230,000.00 | 118,318.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 28,697.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **910,891,015.02** | **393,279,152.18** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 841,869,600.00 | 321,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,039,700.00 | 54,364,065.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 8,981,715.02 | 17,915,087.18 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **119,682,229.86** | **193,828,995.12** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **83,895,653.68** | **117,200,000.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 82,850,653.68 | 117,200,000.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 1,045,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **24,202,700.00** | **69,179,012.00** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 692,200.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,691,612.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,510,500.00 | 39,487,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,791,938.09** | **7,449,983.12** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,791,938.09 | 7,449,983.12 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **41,140,710.89** | **1,678,936.82** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **41,140,710.89** | **1,678,936.82** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,606,414,200.00** | **1,369,371,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,797,600.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,797,600.00** | **-** |
| 120009 | Бусад орлого | 1,797,600.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,604,616,600.00** | **1,369,371,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **848,776,000.00** | **324,108,100.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,776,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 840,000,000.00 | 321,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,108,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **755,840,600.00** | **1,045,263,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 755,840,600.00 | 1,045,263,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,600,516,700.00** | **1,353,862,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,600,516,700.00** | **1,353,862,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,492,647,061.91** | **1,158,613,004.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **340,280,157.48** | **458,999,694.10** |
| 210101 | Үндсэн цалин | 190,115,922.32 | 251,368,128.67 |
| 210102 | Нэмэгдэл | 87,246,693.58 | 140,957,708.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,435,000.00 | 35,714,617.27 |
| 210104 | Урамшуулал | 23,259,390.77 | 30,959,240.09 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,223,150.81 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,369,427.25** | **57,841,729.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,923,485.23 | 39,372,767.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,402,763.03 | 4,632,090.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,722,210.36 | 2,306,145.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 665,542.66 | 2,306,145.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,655,425.97 | 9,224,580.97 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,242,700.00** | **29,663,330.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 999,520.00 | 1,471,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,758,000.00 | 25,010,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,444,180.00 | 3,181,830.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 41,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **300,000.00** | **981,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 981,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **24,866,180.00** | **24,200,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,915,500.00 | 1,324,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,951,000.00 | 3,618,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,999,680.00 | 19,257,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **23,300,000.00** | **29,256,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,300,000.00 | 29,256,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **135,991,717.18** | **182,963,186.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 132,733,020.18 | 179,843,868.34 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000,000.00 | 2,943,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 230,000.00 | 118,318.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 28,697.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **900,296,880.00** | **374,707,965.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 841,797,600.00 | 321,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 58,499,280.00 | 53,707,965.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **107,869,638.09** | **195,248,995.12** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **78,000,000.00** | **117,000,000.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 78,000,000.00 | 117,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **24,077,700.00** | **70,799,012.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 29,691,612.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,077,700.00 | 41,107,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,791,938.09** | **7,449,983.12** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,791,938.09 | 7,449,983.12 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,897,500.00** | **15,509,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,799,900.00** | **15,509,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,799,900.00** | **15,509,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **5,799,900.00** | **15,509,900.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,799,900.00 | 15,509,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,799,900.00)** | **(15,509,900.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 97,600.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **110,700.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **110,700.00** | **110,700.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 102,550,728.00 | 3,567,556.00 | (35,869,818.43) | | 70,248,465.57 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (3,961,570.38) | | (3,961,570.38) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **102,550,728.00** | **3,567,556.00** | **(39,831,388.81)** | **-** | **66,286,895.19** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 46,932,648.98 | | 46,932,648.98 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **102,550,728.00** | **3,567,556.00** | **7,101,260.17** | **-** | **113,219,544.17** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **102,550,728.00** | **3,567,556.00** | **7,101,260.17** | **-** | **113,219,544.17** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **102,550,728.00** | **3,567,556.00** | **7,101,260.17** | **-** | **113,219,544.17** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,678,936.82 | | 1,678,936.82 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **102,550,728.00** | **3,567,556.00** | **8,780,196.99** | **-** | **114,898,480.99** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,045,263,800.00** | **1,037,813,816.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,045,263,800.00** | **1,037,813,816.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **857,138,200.00** | **850,014,804.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **459,524,200.00** | **458,999,694.10** |
| 210101 | Үндсэн цалин | 251,422,000.00 | 251,368,128.67 |
| 210102 | Нэмэгдэл | 140,758,900.00 | 140,957,708.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,382,000.00 | 35,714,617.27 |
| 210104 | Урамшуулал | 30,961,300.00 | 30,959,240.09 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **63,856,700.00** | **57,841,729.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,191,800.00 | 39,372,767.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,916,200.00 | 4,632,090.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,458,100.00 | 2,306,145.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,458,100.00 | 2,306,145.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,832,500.00 | 9,224,580.97 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,674,800.00** | **29,663,330.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,471,500.00 | 1,471,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,016,700.00 | 25,010,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,181,900.00 | 3,181,830.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,700.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **981,000.00** | **981,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 981,000.00 | 981,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **39,943,000.00** | **39,710,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,925,000.00 | 1,924,400.00 |
| 210602 | Тавилга | 15,000,000.00 | 14,910,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,618,000.00 | 3,618,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,400,000.00 | 19,257,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **28,200,000.00** | **28,056,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 28,200,000.00 | 28,056,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **183,114,100.00** | **182,963,186.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 179,867,000.00 | 179,843,868.34 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,943,000.00 | 2,943,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 245,200.00 | 118,318.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 58,900.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **51,844,400.00** | **51,799,865.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,844,400.00 | 51,799,865.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **188,125,600.00** | **187,799,012.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **117,000,000.00** | **117,000,000.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 117,000,000.00 | 117,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **71,125,600.00** | **70,799,012.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,692,000.00 | 29,691,612.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 41,433,600.00 | 41,107,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,045,263,800.00** | **1,037,813,816.88** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,045,263,800.00** | **1,037,813,816.88** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,045,263,800.00 | 1,037,813,816.88 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **324,108,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **324,108,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **324,108,100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,200,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **322,908,100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 321,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,908,100.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **324,108,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **324,108,100.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 321,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,108,100.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар 11,934.7 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 2 төлбөрийн акт тогтоолоо.

**5.1 Төлбөрийн акт**

1. Төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа олгох мөнгөн урамшууллын 9,961.7 мянган төгрөгийг журамд заасан нөхцөл хангаагүй ажилтанд олгосон.

2. Төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 1,973.0 мянган төгрөгийн ХХОАТ -ыг суутган төсөвт төвлөрүүлээгүй.

**5.2 Албан шаардлага**

Байхгүй.

**5.3 Зөвлөмж**

Байхгүй.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **0** | **0,00** | 0 | 0,00 | 0 | 0,00 | 0 | 0,00 | 0 | 0,00 | 0 | 0,00 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Журамд заасан нөхцөл хангаагүй ажилтанд урамшуу-лал олгосон | 1 | 9,961.7 | 1 | 9,961.7 | | | | | | | | |
| ХХОАТ суутгаж шилжүү-лээгүй | 1 | 1,973.0 | 1 | 1,973.0 | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **11,934.7** | **2** | **11,934.7** | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **0** | **0,00** | **0** | **0,00** | **0** | **0,00** | **0** | **0,00** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаар-лалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 113-ХЭА-2025/035/НА-СТА-ТШ3 Чингис хот
А2370452

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 1,973.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.4-т "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй татварын 1,973.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг нарийн бичгийн дарга Ш.Жавхлан, нягтлан бодогч О.Сэржбүдээ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

232550113

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 114-ХЭА-2025/035/НА-СТА-ТШЗ Чингис хот
А2370452

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд заасан нөхцөл хангаагүй 1 ажилтанд 9,961.6 мянган төгрөгийн урамшууллыг үндэслэлгүйгээр олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" -ын 2.1-д "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй олгосон урамшууллын 9,961.6 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн нарийн бичгийн дарга Ш.Жавхлан, нягтлан бодогч О.Сэржбүдээ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

232550114

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112